



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 112

Улаанбаатар хот

Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, 22 дугаар зүйлийн 22.4, 22.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-ыг нэгдүгээр, “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар”-ыг хоёрдугаар, “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Төсвийн шинэчилсэн ангиллыг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн төсвийн төлөвлөлтөд, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төсвийн гүйцэтгэл, тайлагналтад ашиглахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /М.Санжаадорж/, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар /Ж.Дэлгэржаргал/, Төрийн сангийн газар /Б.Цогбадрах/, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Ангилал шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт, тавдугаар хавсралтын 2, 3 дугаар хэсэг, “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Б.ЖАВХЛАН

9763000496

Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 22-ны
өдрийн 112 дугаар тушаалын нээдүгээр хавсралт



ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ

Код	Зардлын зүйл
21	УРСГАЛ ЗАРДАЛ
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил
210101	Үндсэн цалин
210102	Нэмэгдэл
210103	Унаа хоолны Хөнгөлөлт
210104	Урамшуулал
210105	Гэрээт ажлын цалин
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл
210201	Тэтгэврийн даатгал
210202	Тэтгэмжийн даатгал
210203	ҮОМШӨ-ний даатгал
210204	Ажилгүйдлийн даатгал
210205	Эрүүл мэндийн даатгал
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал
210301	Гэрэл, цахилгаан
210302	Түлш, халаалт
210303	Цэвэр, бохир ус
210304	Байрны түрээс
210305	Хөрөнгийн ашиглалтын менежмент
2104	Хангамж, бараа материалын зардал
210401	Бичиг хэрэг
210402	Тээвэр, шатахуун
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр
210404	Ном, хэвлэл
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс
2105	Нормативт зардал
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл
210502	Хоол, хүнс
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл
2106	Эд хогшил, урсгал засварын зардал
210601	Багаж, техник, хэрэгсэл
210602	Тавилга
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл
210604	Урсгал засвар
2107	Томилолт, зочны зардал
210701	Гадаад албан томилолт
210702	Дотоод албан томилолт

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах
2108	Нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох
210803	Даатгалын үйлчилгээ
210804	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх
210810	Тохижилт үйлчилгээ
210811	Судалгаа, хөгжүүлэлт
210812	Хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх үйлчилгээ
2109	Бараа үйлчилгээний бусад зардал
210901	Бараа үйлчилгээний бусад зардал
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал
210903	Мэдээлэл, сурталчилгааны зардал
211	Хүү
2111	Гадаадын зээлийн үйлчилгээний төлбөр
211101	Гадаадын зээлийн үйлчилгээний төлбөр
2112	Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр
211201	Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр
212	ТАТААС
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг
2132	Бусад урсгал шилжүүлэг
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж
213204	Бусад Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж
	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад
213208	төрөөс үзүүлэх дэмжлэг
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ
220001	Барилга байгууламж
221001	Их засвар
222001	Тоног төхөөрөмж
222002	ТЭЗҮ, зураг төсөв
222003	Цахим систем
223001	Бусад хөрөнгө
224001	Стратегийн нөөц хөрөнгө
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ
230001	Эргэж төлөгдөх зээл

231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих
232	Гадаадын төслийн зээлээс санхүүжих :
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих :
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР
240001	Гадаад зээлийн үндсэн төлбөр
241001	Засгийн газрын бондын үндсэн төлбөр
242001	Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөр

Сангийн сайдын 2025 оны 4-дугаар сарын 22-ны
өдрийн 112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛЫН ТАЙЛБАР

Хэрэглээ: Зардлын эдийн засгийн ангилал нь хөтөлбөр болон байгууллагын зардлын бүтцийг тодорхойлдог бөгөөд төсвийн ангиллуудын нэн чухал бүрэлдэхүүн юм. Энэхүү ангиллыг нэгд, эдийн засагт зардлын үзүүлэх үр нөлөөнд дүн шинжилгээ хийхэд; хоёрт, хөтөлбөр болон төсвийн байгууллагын үр ашгийг тооцоолоход; гуравт, төсөв боловсруулж батлуулах, гүйцэтгэлийн тайлан гаргах, зардлын хяналт, аудит хийхэд ашиглана.

Төсвийн захирагчийн үүрэг: Зардлыг ангиллын тодорхойлолтод заасны дагуу нийцүүлж зөв бүртгэх, мэдээлэх, тайлагнах үүргийг төсвийн бүх шатны захирагчид хүлээнэ.

Код	Зардлын эдийн засгийн зүйлс	Тодорхойлолт
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	
21	Урсгал зардал	Тухайн тайлант жилд байгууллагын болон хөтөлбөр, арга хэмжээний хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах жил бүр давтагддаг урсгал шинжтэй бараа, ажил, үйлчилгээний зардлууд.
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	Байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зардлуудыг энэ ангилалд бүртгэнэ. Бараа, ажил, үйлчилгээний зардал нь 1/ цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, 2/ ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 3/ байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 4/ хангамж, бараа материалын зардал, 5/ нормативт зардал, 6/ эд хогшил, урсгал засварын зардал, 7/ томилолт, зочны зардал, 8/ мэргэжлийн үйлчилгээний төлбөр, 9/ бараа үйлчилгээний бусад зардлаас бүрдэнэ.
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	Ажилтанд олгох цалин, хөлс (үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшуулал)

210101	Үндсэн цалин	Цалингийн сүлжээ, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа үндсэн болон байнгын гэрээт ажилтны албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана. Ажилтны үндсэн ажлын зэрэгцээ мэргэжил албан тушаал хавсран, хослон гүйцэтгэсэн, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ээлжийн амралтын олговор, сул зогсолтын үеийн олговор, хүндэтгэн үзэх шалтгаанаар ажилдаа ирээгүй үеийн олговор зэрэг нэмэгдэл цалин хөлс мөн ажил олгогчоос олгох жирэмсэн болон амаржсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр хугацаагаар алдсаны ажлын эхний 5 өдрийн тэтгэмж энд хамаарна.
210102	Нэмэгдэл	Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу олгож байгаа нэмэгдэл цалин хөлс болох алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн, мэргэшлийн зэргийн, ур чадварын, онцгой нөхцөлийн, хөдөлмөрийн нөхцөлийн, ээлжийн амралтаа биеэр эдлээгүй үеийн мөнгөн олговор, шөнө болон илүү цаг ажилласны, нийтээр амрах баярын өдөр ажилласны, алсын болон төрөлжсөн мэргэжлийн дуудлагын, эмнэлгийн тусламж, үйлчилгээний, эрүүл мэндийн салбарын үндсэн цалингийн, анги даасны, нислэгийн үйлчилгээний, заах аргын нэгдэл удирдсаны, кабинет, лаборатори хариуцан ажилласны, гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалтын багш, туслах ажилтны, олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль(ЕБС), ЕБС(лаборатори)-ийн ажилтны, төрийн болон албаны нууц хамгаалах ажилтны, эрх бүхий албан тушаалтны (ЭБАТ) хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажилтны, орон нутагт ажилласны, ур чадварын, цогцостой ажилласны, ёс зүйн, хариуцлагын, хилийн, тусгай албаны, тусгай хамгаалалтын, тусгай сургалтын байгууллагын, цолны нэмэгдэл болон цолны цалин, шүүгчийн цалингийн нэмэгдэл цалин хөлс гэх мэт үндсэн цалингаас хувиар бодож буюу үнэмлэхүй, эсвэл харьцангуй хэмжээгээр тогтоон олгож байгаа нэмэгдэл, нэмэгдэл хөлснүүд багтана.
210103	Унаа хоолны хөнгөлөлт	Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журамд заасны дагуу ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн унааны зардлын 50 хувийг олгох, мөн өдрийн хоолны хөнгөлөлтийг олгох зардлыг энэ ангилалд бүртгэнэ. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Ажил олгогчоос нэгдсэн журмаар ажилчдыг ажилд авчрах болон хүргэх тээврийн гэх мэт зардал. Энэ нь Тээвэр, шатахуун(210402) ангилалд бүртгэгдэнэ.
210104	Урамшуулал	Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу ажлын үр дүнг сар, улирал, жилээр үнэлэн олгох мөнгөн урамшуулал, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын урамшуулал, Татварын улсын байцаагчийн үр дүнгийн мөнгөн урамшуулал,

		Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн урамшуулал гэх зэрэг зардлыг энд бүртгэнэ. Урамшуулал нь ажлын үзүүлэлтээр тооцож хагас бүтэн жилээр цалингийн тодорхой хувиар болон үнэмлэхүй хэмжээгээр тооцон олгох хэлбэртэй байж болно. <u>Хамаарахгүй зүйлс:</u> НДШ суутгахгүй нэг удаагийн шинжтэй шагнал, тэтгэмж урамшууллын зардал. Энэ нь <i>Бусад ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал(213204)</i> эсвэл <i>Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал(213209)</i> аль харгалзах ангилалд бүртгэгдэнэ.
210105	Гэрээт ажлын хөлс	Богино хугацаанд гэрээний дагуу ажиллаж байгаа тооны бус ажилтан, жишээ нь улсын шигшээ багийн тамирчид; шүүхийн иргэдийн төлөөлөгчид; олон нийтийн цагдаа; зөвлөл, хороо, комиссын дарга, гишүүд болон орон тооны бус гишүүд; орон тооны бус байцаагч, төлөөлөгч; хэсгийн ахлагч, олон нийтийн байцаагч; харуул хамгаалалтын ажилтан; архив үйлчилгээний нэгдсэн төвийн гэрээт ажилчид; үндэсний статистикийн хорооны гэрээт судлаачид; галч; малчин; гэрээт ажилтан гэх мэт НДШ суутгах цалингийн зардлууд энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Хуулийн этгээдэд олгох гэрээт ажлын хөлс. Энэ нь <i>Мэргэжлийн үйлчилгээний төлбөр (210801)</i> ангилалд бүртгэгдэнэ.
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	Ажил олгогчоос тайлант жилийн хугацаанд Нийгмийн даатгалын тухай болон Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан хувь хэмжээгээр үндсэн болон нэмэгдэл цалин, түүнтэй адилтгах орлогоос албан журмаар төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг(ЭМД) тооцож энэ ангилалд бүртгэнэ. Эдгээр зардлуудыг бүлгийн дүнгээр хянаж болно.
210201	Тэтгэврийн даатгал	Нийгмийн даатгалын тухай хуульд заасны хувь хэмжээгээр тооцон ажил олгогчоос төлөх тэтгэврийн даатгалын шимтгэл энд хамаарна.
210202	Тэтгэмжийн даатгал	Нийгмийн даатгалын тухай хуульд заасны хувь хэмжээгээр тооцон ажил олгогчоос төлөх тэтгэмжийн даатгалын шимтгэл энд хамаарна.
210203	ҮОМШӨ-ний даатгал	Нийгмийн даатгалын тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцон ажил олгогчоос төлөх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэл энд хамаарна.
210204	Ажилгүйдлийн даатгал	Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу тодорхой хувь хэмжээгээр тооцон ажил олгогчоос төлөх ажилгүйдлийн даатгалын шимтгэл энд хамаарна.
210205	Эрүүл мэндийн даатгал	Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцон ажил олгогчоос төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэл энд хамаарна.

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	Байгууллага үндсэн үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах барилга байгууламжийн ашиглалтын тогтмол шинжтэй урсгал зардлыг энд хамаарна. Эдгээр зардлуудыг бүлгийн дүнгээр хянаж болно. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Байр ашиглалтын ажил үйлчилгээтэй холбоотой гарах цалингийн зардал. Энэ нь <i>Гэрээт ажлын цалин(210105), Хөрөнгийн ашиглалтын менежмент (210305)</i> эсвэл <i>Мэргэжлийн үйлчилгээний төлбөр(210801)</i> аль харгалзах ангилалд бүртгэгдэнэ.
210301	Гэрэл, цахилгаан	Бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээ болон цахилгааны эрчим хүч хэмжих тоолуурын заалтын дагуу байгууллагын хэрэгцээнд ашигласан цахилгаан эрчим хүчний (гэрэл, цахилгаан) төлбөр, өөрийн эх үүсвэрээр цахилгааны эрчим хүчээр хангахад гарсан зардал энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Гэрэл цахилгааны ашиглалттай холбоотой гарсан засвар үйлчилгээний ажлын зардал. Энэ нь <i>Урсгал засвар(210604)</i> болон <i>Мэргэжлийн үйлчилгээний төлбөр(210801), Хөрөнгийн ашиглалтын менежмент (210305)-ийн</i> аль тохирох ангилалд бүртгэгдэнэ.
210302	Түлш, халаалт	Бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээний дагуу төлөх дулааны эрчим хүч болон хэрэглээний халуун ус, түүнчлэн ердийн болон нам даралтад, түүнчлэн бусад технологиор ажилладаг халаалтын зууханд хэрэглэх аргал, нүүрс, мод зэрэг хатуу болон шингэн түлш худалдан авах зардал энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Тээврийн хэрэгсэлд ашиглагдах бензин болон дизель түлш худалдан зардал. Энэ нь <i>Тээвэр, шатахуун(210402)</i> ангилалд бүртгэнэ. Мөн түлш, халаалттай холбоотой засвар үйлчилгээний ажлын зардал. Энэ нь <i>Урсгал засвар(210604)</i> болон <i>Мэргэжлийн үйлчилгээний төлбөр(210801), Хөрөнгийн ашиглалтын менежмент(210305)-ийн</i> аль тохирох ангилалд бүртгэгдэнэ.
210303	Цэвэр, бохир ус	Байгууллага өөрийн дотоод хэрэгцээнд хэрэглэхээр төвлөрсөн ба төвлөрсөн бус усан хангамжаас авч ашигласан цэвэр ус, төвлөрсөн ариутгах татуургын системээр болон тусгай үйлчилгээгээр соруулж зөөвөрлөсөн бохир усны зардал энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Цэвэр, бохир ус ашиглахтай холбоотой гарсан засвар үйлчилгээний ажлын зардал. Энэ нь <i>Урсгал засвар(210604)</i> болон <i>Мэргэжлийн үйлчилгээний төлбөр(210801), Хөрөнгийн ашиглалтын менежмент(210305)-ийн</i> аль тохирох ангилалд бүртгэгдэнэ.

210304	Байрны түрээс	Бусдын өмчлөлийн байр, орон сууцыг ашиглан үндсэн үйл ажиллагаагаа явуулахтай холбогдож гарах талбайн түрээс, албан хэрэгцээнд ашигладаг байгууллагын нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийг бусдын өмчлөлийн гараашинд байрлуулах зардлууд энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Байр түрээслэх гэрээний үндсэн төлбөр багтсанаас бусад хог хаягдлын төлбөр хураамж, цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, харуул хамгаалалтын, дундын хуримтлалын гэх мэт зардал. Энэ нь <i>Урсгал засвар(210604)</i> болон <i>Хөрөнгийн ашиглалтын менежмент (210305)</i> аль харгалзах ангилалд бүртгэгдэнэ. Нэг удаагийн шинжтэй сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зохион байгуулахад ашигласан байрны түрээсийн зардал. Энэ нь <i>Сургалт, семинарын зардал(210902)</i> ангилалд бүртгэгдэнэ.
210305	Хөрөнгийн ашиглалтын менежмент	Төрийн өмчийн барилга байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал, цахилгаан, ус болон дулаан хангамжийн засвар, харуул хамгаалалт, хог хаягдлын гэх мэт үйлчилгээг гуравдагч этгээд буюу мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тохиолдолд энэ ангилалд бүртгэнэ
2104	Хангамж, бараа материалын зардал	Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах бараа материал, хангамжийн зүйлс бэлтгэх зардлууд энд хамаарна. Эдгээр зардлуудыг бүлгийн дүнгээр хянаж болно.
210401	Бичиг хэрэг	Бичгийн болон тооцоолон бодох, хэвлэх, олшруулах техник хэрэгсэлд шаардагдах тууз /хор/, бэх, бичгийн цаас, үдээс, хавчаар, үзэг, харандаа, албан хэргийн хавтас, албан бичгийн хэвлэмэл хуудас болон эдгээртэй адилтгах бусад бараа худалдан авах зардал. Байгууллага өөрийн техник хэрэгслээ ашиглан дотооддоо цөөн тоогоор хэвлэдэг маягт бэлтгэх зардал энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Хэвлэлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр олон тоогоор бэлтгүүлдэг улсын мэдээллийн маягт, гэрчилгээ, лавлагааны хуудас, торгууль шийтгэврийн хуудас хэвлэх гэх мэт маягт бэлтгэх зардал. Энэ нь <i>Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх(210809)</i> ангилалд бүртгэгдэнэ.

210402	Тээвэр, шатахуун	Байгууллага өөрийн хэрэгцээнд буюу байгууллагын нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн ашиглалтад зориулж худалдан авсан шатах, тослох материал, эрх бүхий албан тушаалтнуудад албан ажилдаа өөрийн тээврийн хэрэгслийг ашигласны төлөө олгосон шатахууны талон, гэрээ байгуулсны үндсэн дээр бусдын тээврийн хэрэгслээр ажил, үйлчилгээ гүйцэтгүүлсний хөлс, өөрийн болон бусдын тээврээр халаалтын зориулалттай түлш бэлтгэхэд төлсөн шатахууны зардал, тээвэрлэлтийн ажлын хөлс энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Дулаан, халаалтын зориулалтаар ашиглах түлш болон шингэн түлшний зардал. Энэ нь <i>Түлш, халаалт (210302)</i> ангилалд бүртгэгдэнэ.
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	Албан бичиг, захидал, шуудангаар илгээх зэрэг холбооны байгууллагаар үйлчлүүлэхэд гарсан зардал болон телефон утас, факс, телекс, хот хоорондын яриа, интернэт ашигласны төлбөр болон бусад хураамж энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Компьютерын хэрэглээний программууд, лицензийн төлбөр, тэдгээрийн засвар үйлчилгээтэй холбоотой зардал. Энэ нь <i>Мэдээлэл, технологийн үйлчилгээ(210806)</i> ангилалд бүртгэгдэнэ.
210404	Ном, хэвлэл	Байгууллагын албан ажлын хэрэгцээний зориулалтаар ашиглах дотоод, гадаадын тогтмол хэвлэл захиалах, номын фондыг нэмэгдүүлэх, товхимол, тараах материал хэвлүүлэх зардлууд энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Хэвлэлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр олон тоогоор бэлтгүүлдэг улсын мэдээллийн маягт, гэрчилгээ, лавлагааны хуудас, торгууль шийтгэврийн хуудас хэвлэх гэх мэт маягт бэлтгэх зардал. Энэ нь <i>Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх(210809)</i> ангилалд бүртгэгдэнэ.
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	Энгийн болон аюултай, овор хэмжээ ихтэй хог хаягдлыг хог, хаягдлын тухай хууль болон холбогдох эрх зүйн актын дагуу устгах, ариутгах, тээвэрлэх; хортон шавж, мэрэгчдийн устгал, ариутгал; эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслүүдийг ариутгах, халдваргүйжүүлэхтэй холбоотой гарсан төлбөр болон бусад хураамжууд энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Гуравдагч байгууллагаас авч буй ажил үйлчилгээнээс гадна гарах байгууллагын тогтмол хэрэглээнд зориулсан цэвэрлэгээ, ариутгалтай холбоотой бага үнэтэй бараа материалын зардал. Энэ нь <i>Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс(210406)</i> ангилалд бүртгэгдэнэ.

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	Байгууллагын албан байрны тохижилт, цэвэрлэгээ болон аж ахуйн хэрэгцээний зориулалтаар худалдан авсан бараа, материал, эд зүйлс, тухайлбал угаалгын нунтаг, цэвэрлэгээний бодис, хэрэгсэл цай, кофе гэх мэт бага үнэтэй буюу түргэн элэгдэх эд зүйлсийг худалдан авч шууд зарлагдах үед гарсан зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Мөн хүчний байгууллагын нормд тавигддаг саван, ариун цэврийн хэрэглэлийн зардлууд энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> 210101, 210102, 210103, 210104, 210105 ангилалд багтах зардал.
2105	Нормативт зардал	Эрх зүйн актаар тогтоосон норм, нормативын дагуу тооцон, холбогдох чиг үүргийн дагуу төрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлууд энд хамаарна. Эдгээр зардлуудыг бүлгийн дүнгээр хянаж болно.
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	Тогтоосон норм, нормативын дагуу тоо хэмжээг нь тогтоосон эм (уламжлалт эм, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, урвалж, био-бэлдмэл, оношлуур, эмийн туслах бодис), эмнэлгийн хэрэгсэл (эмчлэх, сувилах, оношлох зорилгоор ашигладаг туслах зориулалтын эд зүйлс болох зүү, тариур, ороох боох материал, нэг удаагийн шинжтэй бусад туслах хэрэгсэл), Дархлаажуулалтын болон Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хуулийн дагуу урьдчилан сэргийлэх болон халдваргүйжүүлэлтийн эсрэг вакцин худалдан авах зардал, түүнчлэн бүх төрлийн лабораторийн урвалж бодис, материалын зардлууд энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Хөрөнгийн шинж чанартай эмнэлгийн тоног төхөөрөмжийн зардал. Энэ нь <i>Тоног төхөөрөмж(222001)</i> ангилалд бүртгэгдэнэ. Хөрөнгийн бус шинж чанартай тоног төхөөрөмж багаж хэрэгслийн зардал. Энэ нь <i>Багаж, техник хэрэгсэл(210601)</i> ангилалд бүртгэгдэнэ.

210502	Хоол, хүнс	Тогтоосон норм, нормативын дагуу хүний тоотой уялдуулж тоо хэмжээг нь тогтоосон хүнсний бүтээгдэхүүн, хоол хүнсээр хангах үйлчилгээний (эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн хоолны зардал, цэцэрлэгийн хүүхдийн хоол, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд болон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн дотуур байрны хоолны зардал, хугацаат цэргийн албан хаагч, сэжигтэн, хоригдлын хоолны зардал, хил дээр ажиллаж байгаа офицер, ахлагчийн хүнсний хангамж) зардал энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Ажилласан хугацаанд хамааруулан хууль журмын дагуу хувь хүнд мөнгөн хэлбэрээр олгож байгаа хоол, хоолны хөнгөлөлтийн зардал. Энэ нь <i>Унаа хоолны хөнгөлөлт(210103)</i> ангилалд бүртгэгдэнэ. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн цай хөтөлбөрт гарах зардал. Энэ нь <i>Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал(213205)</i> ангилалд бүртгэгдэнэ. Хурал зөвлөгөөн сургалт, семинарын хоолны зардал. Энэ нь <i>Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх(210902)</i> ангилалд бүртгэгдэнэ. Ахмад настныг хүлээн авах, хүүхдийн баярын бэлэг бэлтгэх, баяр ёслол, хүндэтгэлийн зоог зохион байгуулахад гарах хоол, хүнсний зүйлс бэлтгэх зардал. Энэ нь <i>Бараа үйлчилгээний бусад зардал(210901)</i> ангилалд бүртгэгдэнэ.
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	Хуулийн дагуу тусгай дүрэмт хувцас хэрэглэх эрх бүхий албан хаагчдын дүрэмт хувцас болон ажлын тусгай зориулалтын нормын хувцас худалдан авах, түүнийг хийлгэхтэй холбогдсон үндсэн, туслах материал болон бусад зардал, эмнэлэг, сургуулийн дотуур байр, цэргийн болон бусад төсөвт байгууллагын хэрэгцээнд ашиглах ор, дэрний хэрэгсэл, бусад зөөлөн эдлэл. Улсын аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагын гүйцэтгэх ажилтан хуульд заасны дагуу дүрэмт хувцасны оронд энгийн хувцас өмсөх зайлшгүй шаардлагатай нөхцөлд нормын хувцасны эдэлгээний хугацаагаар тооцож олгох мөнгөн олговор. Байгууллагын үйлчилгээний ажилтны хувцас, усны гутал гэх мэт ажлын тусгай зориулалтын хувцас, хэрэглэл энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлэх байгууллагын албан хаагчдад олгодог нормын дагуух саван, ариун цэврийн хэрэглэл гэх мэт зардал. Энэ нь <i>Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс(210406)</i> ангилалд бүртгэгдэнэ. Улсыг аюулаас хамгаалах чиг үүрэгтэйгээс бусад байгууллагын ажилтанд олгох дүрэмт хувцасны мөнгөн олговрын зардал. Энэ нь <i>Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг(213204)</i> ангилалд бүртгэнэ.

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	Байгууллага эд хогшил худалдан авах болон үндсэн хөрөнгөнд урсгал засвар, үйлчилгээ хийлгэхтэй холбоотойгоор гарах зардлуудыг тус бүлэгт бүртгэнэ. Эдгээр зардлуудыг бүлгийн дүнгээр хянаж болно. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Хөрөнгийн шинж чанартай багаж хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, их засварын зардал. Энэ нь <i>Хөрөнгийн зардлын(22)</i> аль харгалзах ангилалд бүртгэгдэнэ.
210601	Багаж, техник, хэрэгсэл	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны зориулалтаар ашиглахаар худалдан авах багаж, техник, хэрэгсэл, (лабораторийн хэмжих хэрэгсэл, тохируулга болон засвар үйлчилгээний багаж, дээж авах хуруу шил гэх мэт). Мөн албан хэрэгцээнд ашиглагдах цөөн тоогоор бэлтгэн нийлүүлэх боломжтой ширээний болон зөөврийн компьютер, тог баригч, хэвлэгч, сканер зэрэг тоног төхөөрөмж энд багтана.
210602	Тавилга	Бичгийн ширээ, сандал, шүүгээ гэх мэт тавилга бэлтгэх зардал энд багтана.
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, стандартын дагуу хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай, бээлий, нүдний шил, маск зэрэг хэрэгслийг бэлтгэхэд гарах зардал. Байгаль орчин, хилийн мэргэжлийн хяналтын улсын байцаагч нарын хилийн шалган нэвтрүүлэх цэг болон байгаль орчны талбарт хэрэглэх хувцас, хэрэгслийн зардлууд энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Байгууллагын албан тасалгаа, ариун цэврийн өрөө, гадаад талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний ажилтны хувцас, усны гутал гэх мэт ажлын тусгай зориулалтын хувцас, хэрэглэл, хуулиар тогтоосон салбарын албан хаагчийн дүрэмт хувцасны зардал. Энэ нь <i>Нормын хувцас, зөөлөн эдлэл(210503)</i> ангилалд бүртгэгдэнэ.
210604	Урсгал засвар	Хөрөнгийг хэвийн ашиглахын тулд тогтмол хийгддэг, өмнөх байдалд нь хадгалж/сэргээхэд чиглэсэн урсгал шинжтэй буюу засвар хийх зориулалтаар бэлтгэсэн материал, сэлбэг, засвар, үйлчилгээний ажлын хөлс энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Урсгал засварын үед гарсан овор хэмжээ ихтэй хог хаягдлын зардал. Энэ нь <i>Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал(210405)</i> ангилалд бүртгэгдэнэ.
2107	Томилолт, зочны зардал	Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тусгайлсан удирдамж, хөтөлбөрийн дагуу дотоодод болон гадаад улс оронд албан ажлын томилолтоор ажиллахад гарах тээвэр, байрны болон хоолны зардал, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, гадаад улс орноос ирэх зочин, төлөөлөгчийг хүлээн авч байршуулахтай холбогдох зардлууд энд хамаарна. Эдгээр зардлуудыг бүлгийн дүнгээр хянаж болно.

210701	Гадаад албан томилолт	Төсөвт байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрийн дагуу тусгайлсан удирдамж, хөтөлбөрийн дагуу гадаад улс оронд албан ажлын томилолт (ажлын айлчлал, хурал, зөвлөгөөн, семинарт оролцох, гэрээ хэлцэл байгуулах гэх мэт)-оор ажиллахад гарах зах зээлийн дундаж ханшаар тогтоосон тээвэр, Сангийн сайдын баталсан нормативын дагуу олгох байр, хоолны зардал болон бэлэг дурсгалын зүйлс худалдан авах зардлууд хамаарна. Төрийн өндөр, дээд хэмжээний уулзалтад оролцох зардлыг зохион байгуулагч байгууллагаас нэгдсэн журмаар төсөвлөсний дагуу зардал энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Гадаад улс оронд зохион байгуулах сургалтад байгууллагын төсвөөр санхүүжүүлж оролцуулахтай холбоотой зардал. Энэ нь <i>Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх(210902)</i> ангилалд бүртгэгдэнэ.
210702	Дотоод албан томилолт	Төсөвт байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий алба тушаалтан болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрийн дагуу тусгайлсан удирдамж, хөтөлбөрийн дагуу дотоод албан ажлын томилолтоор нийслэл хот, аймаг, сумдад ажиллахад гарах хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслийн тарифаар тооцсон тээвэр (нийтийн тээврийн хэрэгслээр зорчих боломжгүй нөхцөлд авто машин түрээслэхтэй холбоотойгоор гарах зардал, эсвэл бензин, шатахууны зардал), Сангийн сайдын баталсан нормативын дагуу тооцсон байр, хоолны зардал энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Бэлэг дурсгалын зүйлс худалдан авах зардал. Энэ нь <i>Бараа үйлчилгээний бусад зардал(210901)</i> ангилалд бүртгэгдэнэ.
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	Монгол Улсад гадаад улс орнуудаас албан ажлын айлчлалаар ирэх зочин, төлөөлөгч, Монгол Улсаас гадаад улс оронд суугаа дипломат төлөөлөгчийн газруудад Монгол Улсын болон бусад орны албан төлөөлөгч айлчлахтай холбогдон гарах зочид буудал, хоол, унаа болон бэлэг дурсгалын эд зүйлс бэлтгэх зардал энд хамаарна. Оросын Холбооны Улс(ОХУ) болон Бүгд Найрамдах Хятад Ард Улстай(БНХАУ) хил залгадаг аймгуудад найрамдлын арга хэмжээг зохион байгуулахтай холбогдуулж зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг энд хамаарч болно.
2108	Нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	Байгууллага гуравдагч этгээдийн багц үйлчилгээг худалдан авахад төлөх зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Тус бүлгийн зардлуудыг эдийн засгийн ангилал тус бүрээр хянана. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Хувь хүнд ажил үйлчилгээний авсны төлөөсөнд олгож байгаа НДШ тооцогдох цалин хөлс,

		урамшуулал. Энэ нь 2101 бүлгийн харгалзах зардлын зүйлд бүртгэгдэнэ.
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	Байгууллага өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ шаардлагатай ажил, үйлчилгээг мэргэжлийн ур чадвар, тусгай зөвшөөрөлтэй гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхэд төлөх төлбөрийг хэлнэ. Үүнд ойжуулалт болон ойн нөхөн сэргээлт, хортон шавжтай тэмцэх, малын вакцинжуулалт гэх мэт үйлчилгээг худалдан авахад төлөх энэ бүлэг(2108)-т зааснаас бусад ажил, үйлчилгээний төлбөр энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> - Барилга байгууламжийн зураг төсөл, инженерийн тооцоо. Энэ нь <i>ТЭЗҮ-зураг төсөө (222002)</i> ангилалд бүртгэгдэнэ. - Орон нутгийн хот тохижилт Энэ нь <i>Тохижилт үйлчилгээ (210810)</i> ангилалд бүртгэгдэнэ. - Байгууллага өөрийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, байгууламж, тээврийн хэрэгсэлд урсгал шинжтэй засварын материалын болон ажлын хөлс. Энэ нь <i>Урсгал засвар (210604)</i> ангилалд бүртгэгдэнэ. - Төрийн өмчийн барилга байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал, цахилгаан, ус болон дулаан хангамжийн засвар, харуул хамгаалалт, хог хаягдлын гэх мэт үйлчилгээг гуравдагч этгээд буюу мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх. Энэ нь <i>Хөрөнгийн менежментийн үйлчилгээ (210305)</i> ангилалд хамаарна
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	Гуравдагч этгээдээр аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоолгох үйлчилгээг хийлгэхэд гарах зардал, тухайлбал, төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайланд аудит хийлгэх, тусгай үйлчилгээний магадлан итгэмжлэл хийлгэх гэх мэт зардлууд энд хамаарна.
210803	Даатгалын үйлчилгээ	Хуульд заасан заавал даатгалын төрлүүдэд байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг даатгуулж төлбөрийг нь төсвөөс санхүүжүүлэхээр заасан тохиолдолд гарах хураамж энд хамаарна.
210804	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	Хууль тогтоомжид заасны дагуу байгууллагын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн татвар, агаарын бохирдлын төлбөр, зам ашигласны төлбөр, тээврийн хэрэгслүүдийг оношилгоонд хамруулах үйлчилгээний төлбөр энд хамаарна.энд хамаарна.
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	Компьютерын хэрэглээний программуудын эрхийн төлбөр, лицензийн төлбөр, тэдгээрийн засвар үйлчилгээг гуравдагч этгээдээс худалдан авах төлбөр энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Шуудангийн үйлчилгээ, интернэтийн төлбөр, телефон утас яриатай холбоо гарсан зардал.

		Энэ нь <i>Шуудан холбоо, интернэтийн төлбөр(210403)</i> ангилалд бүртгэгдэнэ.
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж	Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй газар ашигласны төлбөр болон байгалийн баялаг ашигласны төлбөр гэх мэт нийтлэг төлбөрүүд энд хамаарна. Түүнчлэн банк болон санхүүгийн бусад байгууллагаар дамжуулан хийсэн гүйлгээний шимтгэл болон үйлчилгээний хураамжууд энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Үндсэн өр төлбөрийн хүүгийн зардал. Энэ нь <i>Хүү(211)</i> ангилалд бүртгэгдэнэ.
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	Байгууллагын албан ажлын хэрэгцээний зориулалтаар ашиглах хэвлэлийн маягт, торгууль шийтгэврийн хуудас гэх мэт маягт, үнэт цаас бэлтгэх, хэвлэхтэй холбоотойгоор гарах зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Иргэний болон жолооны үнэмлэх хэвлэх зардлыг энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Байгууллага өөрийн техник хэрэгслээ ашиглан дотооддоо цөөн тоогоор хэвлэдэг маягт бэлтгэх зардал. Энэ нь <i>Бичиг хэрэг(210401)</i> ангилалд бүртгэгдэнэ.
210810	Тохижилт үйлчилгээ	Орон нутгийн хот тохижуулалт, цэцэрлэгжүүлэлт, хөшөө дурсгалын арчилгаа хамгаалалтыг орон нутгийн өмчит хуулийн этгээд, эсхүл хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардлыг энэ ангилалд бүртгэнэ. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Байгууллагын барилга байгууламжид хийх тохижилт, засвар Энэ Урсгал засвар (210604) ангилалд бүртгэгдэнэ.
210811	Судалгаа хөгжүүлэлт	Шинжлэх ухаан, технологи, нийгэм, эдийн засгийн чиглэлээр шинэ мэдлэг, шийдэл, аргачлал бий болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээ болон үйл ажиллагааг сайжруулах зорилгоор судалгаа хийх, туршилт, боловсруулалт, загварчлал, шинэлэг шийдэл боловсруулахад зарцуулах зардал.
210812	Хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх үйлчилгээ	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ буюу гуравдагч этгээдийн багц үйлчилгээг худалдан авахад төлөх мэргэжлийн үйлчилгээ (210801)-нд хамаарахаас бусад ажил, үйлчилгээний төлбөр энд хамаарна.

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагаатай холбоотой гарах бусад бараа, үйлчилгээнд төлөх зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Тус бүлгийн зардлуудыг эдийн засгийн ангилал тус бүрээр хянаана.
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагаатай холбоотой гарах бусад бараа, үйлчилгээнд төлөх зардал буюу энэ ангилалд тусгайлан заагдаагүй боловч хууль, тогтоомж, эрх зүйн бусад шийдвэрийн хүрээнд зөвшөөрөгдсөн, ажил, үйлчилгээ үзүүлэгчид төлөх ёстой төлбөр хураамжууд энд хамаарна.
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд жил бүр албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах, дадлага сургуулилт хийлгэх зорилгоор гадаад, дотоодод сургалтад хамруулахад шаардагдах сургалтын төлбөр, сургалттай холбогдсон материал бэлтгэх, багшийн хөлс төлөх, сургалтын өрөө тасалгаа, тоног төхөөрөмж түрээслэх зэрэг зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Мөн бүх шатны боловсролын байгууллагуудын үзүүлэн таниулах материал, хичээлийн ба лабораторийн багаж, бодис худалдан авах, сургуулиудын хичээлийн байрандаа буюу хичээлийн байрнаас гадагш явж дадлага хийхтэй холбогдох зардлууд энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Сургалтад оролцох томилолт, унаа хоолны зардал. Эдгээр нь <i>Дотоод албан томилолт(210701)</i>, <i>Гадаад албан томилолт(210702)</i> ангилалд бүртгэгдэнэ.
210903	Мэдээлэл сурталчилгааны зардал	Байгууллага, салбар, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг олон нийтэд болон олон улсын түвшинд сурталчлах, таниулах зорилгоор хэвлэл мэдээлэл, цахим болон хэвлэмэл материал, арга хэмжээний сурталчилгаа, таних тэмдэг, самбар хэвлэх зэрэгт зарцуулах зардал.
211	Хүү	Эрх бүхий байгууллагаас гадаад дотоодын банк, санхүүгийн байгууллагаас зээл авч ашиглахыг зөвшөөрч шийдвэрлэсэн болон ерөнхий гэрээтэй холбоотой шимтгэл, авч ашигласан зээлийн үлдэгдэлд төлсөн хүүгийн зардал энд хамаарна. <u>Хамаарахгүй зүйлс:</u> Үндсэн өр төлбөрийн хүүгийн зардлаас бусад гүйлгээний төлбөр болон бусад санхүүгийн үйлчилгээний хураамж зардал. Энэ нь <i>Банк,</i>

		санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж(210808) ангилалд бүртгэгдэнэ.
2111	Гадаадын зээлийн үйлчилгээний төлбөр	Хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээрийн дагуу Гадаад Улсын Засгийн газар, Олон улсын байгууллагаас авсан Засгийн газрын зээлийн хүү, хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэлийн төлбөр, Засгийн газраас олон улсын зах зээлд гаргасан үнэт цаасны хүүгийн төлбөр болон үнэт цаас гаргахтай холбоотой хүүгийн төлбөр энд хамаарна.
211101	Гадаадын зээлийн үйлчилгээний төлбөр	
2112	Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр	Засгийн газраас дотоодын зах зээлд гаргасан үнэт цаасны хүүгийн төлбөр болон Монгол банк, санхүүгийн бусад байгууллагаас авсан Засгийн газрын зээлийн хүүгийн төлбөр, Засгийн газрын гаргасан вексель, бусад өрийн бичгийг мөнгөжүүлэлттэй холбоотой хүүгийн зардал энд хамаарна.
211201	Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр	
212	Татаас	Төрийн өмчит болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зорилготой болон төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд гарч буй тодорхой зориулалтаар олгож байгаа урсгал шилжүүлэг буюу татаас энд хамаарна.
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	Төрийн өмчит байгууллагад олгож байгаа татаас энд хамаарна.
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	Үйлдвэрлэлийн хэмжээ, үнэ, эсвэл тухайн жилийн алдагдлыг нөхөх зорилгоор хувийн хэвшлийн байгууллагад олгож байгаа татаас энд хамаарна.
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	
213	Урсгал шилжүүлэг	Хууль тогтоомж болон төрийн бусад шийдвэрийн дагуу Засгийн газраас олгох нэг болон түүнээс дээш удаа олгох дэмжлэг, тусламжууд энд хамаарна.

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	Хууль тогтоомж болон бусад шийдвэрийн дагуу төсвөөс олгох хандив, дэмжлэг, тусламжууд энд хамаарна.
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	Засгийн газраас дотоодын хүлээн авагчид хууль болон бусад шийдвэрийн дагуу төсвөөс олгох дэмжлэг, тусламж (санхүүгийн дэмжлэг, төрийн чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн шилжүүлгүүд, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, нөхөн олговор авагчдын өмнөөс төлөх НДШ, ЭМД-аас эмнэлгүүдэд өгөх санхүүжилт, дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого, улс төрийн суудалтай намуудад төсвөөс олгох дэмжлэг, төрийн бус байгууллагад төсвөөс олгох дэмжлэг,) энд хамаарна.
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	Хоёр болон олон талт гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргийн дагуу Гадаад Улсын Засгийн газар, Олон улсын байгууллагад төлөх гишүүнчлэлийн хураамж болон төрийн бусад шийдвэрийн дагуу гадаад улс орнуудад олгох хандив, тусламж энд хамаарна.
2132	Бусад урсгал шилжүүлэг	Хууль тогтоомж болон төрийн бусад шийдвэрийн дагуу олгох нийгмийн хамгааллын шилжүүлгүүд энд хамаарна.
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр энд хамаарна.
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, нөхөн олговор, дэмжлэг, үйлчилгээ, тусламж энд хамаарна.
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	Төрийн албаны хууль болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр, нийтлэг баталгаа, нэмэгдэл баталгаатай тус тус холбоотой ажил олгогчоор дамжуулан олгох нэг удаагийн тэтгэмж, дэмжлэг энд хамаарна.
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	Нийгмийн хамгааллын чиглэлээр төрөөс иргэдэд үзүүлж буй бусад тэтгэмж, дэмжлэгийн зардлууд энд хамаарна.
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	Төрийн албаны тухай хуульд заасны дагуу албан хаагчийн ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явах бол ирэх, очих замын зардлыг, эсхүл магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилалд ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгоход шаардагдах зардлыг энэ ангилалд тусгана. Ажил олгогчоор дамжуулан олгох нэг удаагийн тэтгэмж, дэмжлэг энд хамаарна.
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн эсхүл төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрч төрийн албанаас чөлөөлөгдөх албан хаагчид Төрийн албаны тухай болон бусад холбогдох хуульд заасны дагуу нэг удаагийн тэтгэмж олгоход шаардагдах зардал энд хамаарна.
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан	Холбогдох хууль, тогтоомжийн дагуу тодорхой хугацааны давтамжтай дэмжлэг үзүүлэхэд шаардагдах зардал энд хамаарна.